Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны
2023 оны 06 сарын 23 өдрийн
118 албан бичгийн хавсралт

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2023 ОНЫ 6 ДУГААР САРЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2023 оны 6 дугаар сарын 23-ны өдөр

| № | Хийгдэх ажил | Хүрэх үр дүн | Хугацаа | Биелэлт |
|---|---|---|---|---|
| 1 | Хугацаатай мэдээ, тайлан гаргах | Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг | дараа сарын 02-ны дотор | Тайлант хугацаанд манай байгууллагад 103,537.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 86,450.2 мянган төгрөгийг зарцуулж 17,087.3 мянган төгрөг хэмнэсэн. |
| | | Шилэн дансны мэдээллийг нэгдсэн цахим санд оруулах | Дараа сарын 08-ны дотор | Тайлант хугацаанд оруулбал зохих 13 мэдээллийг хуулийн хугацаанд нь оруулсан. |
| | | Нийгмийн даатгалын тайлан гаргаж, хүргүүлэх | Дараа сарын 05-ны дотор | 6-р сарын НДШ-ийн тайланг хуулийн хугацаанд илгээж, тайлагнасан. |
| 2 | Санхүүгийн төлөвлөгөөт хяналт шалгалт хийх | Хяналт шалгалтын үр дүн | 6 сард | Санхүүгийн хяналт шалгалтыг төлөвлөгөөт 5, төлөвлөгөөт бус 2 байгууллагад нийт 7 байгууллагад хийж 273.511,7 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 7.969,9 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгуулахаар, 7.212,2 мянган төгрөгийг хувь хүнд нь буцаан олгуулахаар, улсын төсөвт төвлөрүүлэхээр 12.016,8 мянган төгрөг нийт 27.189,9 мянган төгрөгийн улсын ахлах байцаагчийн нөхөн төлбөрийн акт тогтоож 18.971,3 мянган төгрөгийг зөрчилийг хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн. Мөн 12.224,6 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулахаар |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | хугацаатай албан шаардлага хүргүүлж, 215.116,9 мянган төгрөгийн зөрчилийг арилгуулахаар зөвлөмж өгч ажиллалаа. Одоогоор Баянтал сумын ЗДТГ-ын санхүүгийн баримтад хяналт шалгалт хийгдэж байна. Шалгалтын явц 75 хувьтай үргэлжилж байна.<br>Үр дүн: Актын барагдуулалт 42,3 хувь. Нийт тогтоосон нөхөн төлбөрийн актаас 7.212,2 мянган төгрөгийн акт барагдсан, 7.277,9 мянган төгрөгийн актын барагдуулах хугацаа нь болоогүй байна. |
| 3 | Говьсүмбэр аймгийн Баянтал сумын ЗДТГазрын 2020-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх | Санхүүгийн сахилга бат сайжирна | 6 сард | Баянтал сумын ЗДТГазрын 2020-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж байна. Шалгалтын явц 75 хувьтай байна. |
| 4 | Сүмбэр сумын 5-р цэцэрлэгийн 2022-2023 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийх | Байгууллагын үйл ажиллагаа сайжирна | 6 сард | Байгууллагын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Сүмбэр сумын 5-р цэцэрлэгийн 2022-2023 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийлээ. Дотоод аудитаар тус байгууллагын үл ажиллагааг “Сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлтийг өгч байна. Байгууллагын засаглал, эрсдлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь “давтамжтай буюу 2-р түвшин”-д байна гэж үнэлэгдэв. Шалгалтаар илэрсэн зөрчлийн хүрээнд 14 зөвлөмж өгсөн. |
| 5 | Сүмбэр сумын ЗДТГ-2021-2023 оны үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийх | Санхүүгийн сахилга бат сайжирна | 6 сард | Сүмбэр сумын Засаг даргын тамгын газрын 2021-2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж дууслаа. Шалгалтаар нийт 9.794,7 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 1.001,9 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоолоо. Дээрх |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | зөрчлийг дахин гаргахгүй байх талаар зөвлөгөө өгч ажиллалаа. |
| 5 | Сүмбэр сумын ЗДТГ-2022 он, 2023 оны эхний 5 сарын үйл ажиллагаанд дотоод аудит хийх | Санхүүгийн сахилга бат сайжирна | 6 сард | Сүмбэр сумын ЗДТГ-ын 2022 он, 2023 оны эхний 5 сарын үйл ажиллагаанд дотоод аудит хийж байна. Шалгалтын явц 95 хувьтай байна. |
| 6 | Шивээговь сумын ЗДТГ-ын 2022-2023 оны үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийх | Санхүүгийн сахилга бат сайжирна | 6 сард | Шивээговь сумын Засаг даргын тамгын газрын 2022-2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж дууслаа. Шалгалтаар нийт 40.354,9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 6.276,0 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгуулахаар, 7.654,8 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага, 26.424,1 мянган төгрөгийн зөрчлийг дахин гаргуулахгүй байхаар зөвлөмж хүргүүлэв. Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг “Их” эрсдэлтэй гэж үнэлэв. |
| 7 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангуулах | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдах | 6 сард | Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу аймгийн төсөвт, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нийт 43 байгууллагын шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг. Эхний 5 сарын шилэн дансны мэдээ оруулалтын байдал 98.1 хувьтай байна. Энэ нь өмнөх сараас 1.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. |
| 8 | Мэдээллийн ил тод байдлыг хангах | Мэдээллийн ил тод байдал хангагдах | 6 сард | Мэдээллийн ил тод байдлыг хангаж, ойлгомжтой байлгах үүднээс байгууллагын веб хуудас болон самбарт 5 мэдээ байршуулсан. Байгууллагын үйл ажиллагааг иргэдэд мэдээлсэн. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 9 | Бусад ажил | Байгууллагын үйл ажиллагаа сайжирна. | 6 сард | Аймгийн удирдах ажилчдын шуурхай зөвлөгөөний 2 удаагийн хурлаас өгсөн 4 үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлсэн.<br><br>Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулагддаг "7:4:10" вебинар сургалтад 7хоног бүрийн Пүрэв гарагт албан хаагчид бүрэн хамрагдаж байна. Тайлант хугацаанд дараах сэдвээр сургалт зохион байгуулагдсан байна. Үүнд.<br>1. "Хувь хүний хөгжлийг дэмжих амьдрах стратеги" VI/8<br>2. "Монгол мандсан шалтгаан "- VI/15<br><br>"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Сум дундын Ойн ангийн зурвас газарт хувиарлагдсан талбайд мод тарих заавар зөвлөмжийн дагуу байгууллагын 4 албан хаагч 20 ширхэг хайлаасны суулгацыг орон нутгийн мэргэжлийн байгууллага болох Сум дундын ойн ангиас худалдан авч тарьж усаллаа.<br>2014 оны талбайд мод арчилгаа, усалгааг VI/07, VI/19-ны хуваарьт өдрүүд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:<br>1. Мод бүрийн тогоог дахин засаж, тогоолж, усалгааны үйл ажиллагааны бэлтгэл хангасан.<br>2. Орчны хог хаягдлыг цэвэрлэж хогийг хогийг цэгт хаясан.<br>3. Хариуцсан талбайн модыг бүрэн усалсан.<br><br>2023 оны 06 дугаар сарын 15-ны өдөр Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад 1 албан хаагч хамрагдсан. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | Шинэ шилэн дансны мэдээллийн санд хэрхэн оруулах тухай мэргэжил аргазүйн сургалт, зөвөлгөөг дараах байгууллагын санхүүч нар өгч ажилласан болно. Үүнд:<br>- Сүмбэр сумын ЗДТГ<br>- Стандартчил хэмжилзүйн хэлтэс<br>- Орон нутгийн өмчийн газар<br>- Халамжийн сан<br>- Байгаль орчин аялал жуулчлалын газар<br>- Авто замын сан |
| | | | | 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдөр аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулагдсан Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системийн IRP хариуцсан албан хаагчдыг чадахижуулах сургалтад 6 албан хаагч хамрагдсан. |

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

Дотоод аудитор: Л.Эрдэнэчимэг